

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2021.10.01

Эрчим хүчний яам нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд эрх бүхий тендерт оролцогчдоос “УБДС ТӨХК-д лабораторийн багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх” тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үнийн санал урилга нь 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр “UNDB” цахим <https://devbusiness.un.org/> хаяг-т нийтэлсэн Төслийн Худалдан авах ажиллагааны Ерөнхий мэдэгдлийн дагуу зарлагдаж байна.

Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА: Бараа, Ажил, Зөвлөх ба Зөвлөхийн бус үйлчилгээ (2016 оны 7 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн)- ний дагуу үнийн санал авах аргаар явуулах бөгөөд худалдан авах ажиллагааны журамд тодорхойлсон эрх бүхий бүх тендерт оролцогчдод нээлттэй байна. Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогыг уг журмын 3.14. Сонирхлын зөрчил хэсэгт заасныг мөрдөнө үү.

Оролцохыг сонирхсон этгээд нь tortulga@energy.gov.mn цахим хаягаар албан хүсэлт гаргаж дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.

Оролцогч нь үнийн саналаа 2 хувь бэлтгэж ирүүлэх ба хуудас бүрийг дугаарлаж материал тус бүрийг нь битүүмжлэн **2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 11:00 цаг эсвэл түүнээс өмнө** Эрчим хүчний яаманд цаасаар ирүүлнэ. Үнийн саналыг цахимаар хүлээн авахгүй. Хугацаа хоцорсон үнийн саналыг хүлээн авахаас татгалзана.

Тендерт оролцогч тухайн тоног төхөөрөмжийг нийлүүлж туршиж тохируулж хүлээлгэн өгөх болон туршлагын дараах шаардлагыг хангасан байн. Үүнд:

1. Сүүлийн 3 жил (“2018, 2019, 2020”) аль нэг жилд **237,977,067.0 (Хоёр зуун гучин долоон сая есөн зуун далан долоон мянга жаран долоон)** төгрөгөөс багагүй борлуулалтын орлоготой байна.
2. Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолт;
3. Тендер оролцогч аж ахуйн нэгж нь сүүлийн 2 жилд аливаа шүүхийн зарга маргаанд хариуцагчаар оролцож ял шийтгэл, өр төлбөртэй нь тогтоогдож байгаагүй тухай шүүхийн тодорхойлолт.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. “Үгүй”

Оролцогчид нь үнийн санал авах баримт бичгээс дэлгэрэнгүй шаардлагыг үзнэ үү.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 11:00 цагт** Эрчим хүчний яамны хурлын зааланд нээнэ.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,
Эрчим хүчний яам, Засгийн газрын ХИҮ байр, 3 давхар, 301 тоот
өрөө, 51263074, tortulga@energy.gov.mn**